

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ, АР НАЙМГАНЫ ДУНД  
ХЭСЭГ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН  
ТАЙЛАН**

/ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-005028 /

/ АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6195598 /

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОБНУГ-ын шинжээч...../ /

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын

газрын мэргэжилтэн...../ С.Эрдэнэцогт /

Биелэлтийг тайлагнасан:

“Хаан булаг интернэйшнл ” ХХК-ийн гүйцэтгэх захирал ...../Б.Баярбаатар /

“Хаан булаг интернэйшнл” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн...../ Э.Намсрай /

2025 он

## **ГАРЧИГ**

1. ОРШИЛ .....	5
2. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	7
3. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ .....	7
3.1 Агаар .....	7
3.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөц .....	9
3.3 Хөрсөн бүрхэвч .....	11
3.4 Ургамлан нөмрөг .....	13
3.5 Амьтны аймаг .....	14
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	15
4.1 Биологийн нөхөн сэргээлт .....	15
5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ. ....	15
5.1 “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” ний хүрээнд 5000 ширхэг мод тарих.....	15
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	17
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	17
7.1 Археологийн дурсгал .....	17
7.2 Палеонтологийн дурсгал.....	18
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	18
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	24
9.1 Ахуйн хог хаягдал .....	24
9.2 Аюултай хог хаягдал .....	26
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	27
10.1 АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ.....	27
10.2 ХӨРСНИЙ БОХИРДЛЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ.....	29
10.3 УУРХАЙН УСНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ.....	29
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	31
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	32
13. ДҮГНЭЛТ.....	34

## **ЗУРГЫН ЖАГСААЛТ**

Зураг.1 Агаарын бохирдлын мониторингийн цэгүүд байгуулж хэмжилт хийв. 5 сар.....	7
Зураг.2 Агаарын чанарыг хэмжсэн багаж.....	8
Зураг.3 Агаарын бохирдлын мониторингийн цэгүүд байгуулж хэмжилт хийв. 8 сар.....	9
Зураг.4 Үерийн далан сайжруулалт хийсэн байдал.....	9
Зураг.5 Шатахуун түгээх хэсэг болон тосны цэгийг хатуу хучилттай болгосон .....	10
Зураг.6 Үерийн далан хашаажуулалт хийсэн байдал.....	10
Зураг.7 Эргэлтийн уснаас тогтмол шинжилгээ авч, бохирдсон эсэхийг хянаж ажилласан.11	
Зураг.8. Шимт хөрсний овоолго.....	12
Зураг.9 Кэмтийн ногоон байгууламж, явган хүний зам.....	12
Зураг.10 Нефтийн бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд авах арга хэмжээ, Spill kit / Асгаралт шингээгч /.....	13
Зураг.11 Нийт ажилчдад тогтоосон тээврийн замаас бусад газраар явуулахгүй байх талаар зааварчилгаа өгөв.....	13
Зураг.12 Шувуу үргээгч.....	14
Зураг.13 Бэлдсэн шуудуугаа шимт хөрсөөр дүүргэж тарилт хийв. 10 сар.....	15
Зураг.14 Бэлдсэн шуудуугаа шимт хөрсөөр дүүргэж тарилт хийв. 10 сар.....	15
Зураг.15 3.61 га техникийн нөхөн сэргээлт хийхээс өмнө.....	16
Зураг.16 3.61 га техникийн нөхөн сэргээлт хийсэний дараа.....	16
Зураг.17 3.61 га техникийн нөхөн сэргээлт харьцуулсан зураг.....	17
Зураг.18 Сургалтад хамрагдсан ажилчид, сертификат.....	18
Зураг.19 Аянга зайлуулагч.....	19
Зураг.20 Засвар, үйлчилгээний төв, зөөврийн бетонон хавтан, бетоноор доторлосон нүхэн яам.....	20
Зураг.21 Анхааруулах тэмдэгүүд .....	20
Зураг.22 Хориглох. тэмдэгүүд.....	21
Зураг.23 Дарааллын тэмдэгүүд.....	21
Зураг.24 Заах тэмдэгүүд.....	21
Зураг.25 Гэрэл ойлгогчтой тууз наасан техникүүд.....	22
Зураг.26 Цугларах цэг.....	22
Зураг.27 Гал унтраах техник, багаж хэрэгсэл галын булан.....	23
Зураг.28 Автосамсвалдуудад галын хор байруулсан байдал.....	23
Зураг.29 Галын булан болон экскаворуудад галын хор байрлуулав.....	24
Зураг.30 Хатуу хог хаягдал түр хадгалах, ангилан ялгах байр.....	24

Зураг.31 Ангилан ялгалтын хогын сав.....	25
Зураг.32 Жавлиний уусмал, хлорминоор ариутгал халдваргүйжүүлэлт хийв.....	25
Зураг.33 Сургалтанд хамрагдсан ажилчид.....	26
Зураг.34 Хуучин тосны цэг, байгуулж хашаажуулав.....	26
Зураг.35 Дахин боловсруулах үйлдвэрт аюултай хог хаягдлаа нийлүүлэв.....	27
Зураг.36 Агаарын хяналт шинжилгээний багаж.....	28
Зураг.37 Агаарын чанарын хэмжмилт.....	29
Зураг.38 Засвар, ШТС-ийн талбайгаас дээж авч буй байдал.....	29
Зураг.39. Шимт хөрсний дээж авч буй байдал.....	29
Зураг.40 Ундны усны дээж авч буй байдал.....	30
Зураг.41 Уурхайн цэвэрийн, бохирын нуурын уснаас дээж авч буй байдал.....	30
Зураг.42 Технологийн процесс, паспорт.....	31
Зураг.43 Сумын нээлттэй өдөрлөгт тухайн жилийн байгаль хамгаалах талаар хийсэн ажлыг танилцуулав.....	32

## **ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ**

*Хавсралт.1 Улсын бүртгэлийн гэрчилгээ*

*Хавсралт.2 Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл*

*Хавсралт.3 Лавлагаа*

*Хавсралт.4 Усны гэрээ, дүгнэлт, Хаягдал усны дүгнэлт, Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл*

*Хавсралт.5 Газар эзэмшүүлэх гэрээ*

*Хавсралт.6 Нөхөн сэргээлтийн 50% барьцаа байршуулсан баримт*

*Хавсралт.7 Уурхайн шимт хөрстэй ажиллах журам*

*Хавсралт.8 Ургамлын мониторинг судалгааны тайлан*

*Хавсралт.9 “Археологи угсаатан зүйн судалгаа” тайлан*

*Хавсралт.10 Палеонтологийн тандан судалгааны тайлан дүгнэлт*

*Хавсралт.11 Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө*

*Хавсралт.12 Газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгаа.*

*Хавсралт.13 2025 оны хог хаягдлын гэрээ*

*Хавсралт.14 Техникийн хаягдал тос, тосолгооны шингэний хаягдлыг хүлээлгэн өгөх гэрээ*

*Хавсралт.15 “ Монголын хүрээлэн буй орчны нийгэмлэгээс” авсан сургалт сертификат*

*Хавсралт.16 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тайлан 5 сар*

*Хавсралт 17 Галын аюулгүй байдлын дүгнэлт*

## 1. ОРШИЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах батлах, тайлагнах журмын дагуу боловсруулаа. Төв аймгийн Заамар сумын нутаг дахь “Ар наймганы дунд хэсэг” алтны шороон ордын 2025 онд олборлох явцад эвдрэлд өртсөн болон өмнөх жилүүдэд нөхөн сэргээлт хийгдээгүй орхисон талбайнуудад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг ордын уул техникийн нөхцөлтэй уялдуулан хийж гүйцэтгэв.

Уг алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн тодотголыг “Товь хангайн төгөл ” ХХК 2022 онд хийж БОАЖЯ-ны, Хүрээлэн буй орчин, Байгалийн нөөцийн удирдлагын газраар батлуулсан. Ашиглалтын MV-005028 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбай нь М-48-137, М-48-138 хавтгайд Төв аймгийн Заамар сумын нутаг Ар наймган нэртэй газарт оршино.

Талбайн хэмжээ 1.252.6 га болно. Талбайн булангийн цэгийн солбицлууд:

Цэг	Уртгаг	Өргөрөг	Цэг	Уртгаг	Өргөрөг
1	104 29'00"	48 17'43"	28	104 29'59.92"	48 17'34.36"
2	104 29'05.74"	48 17'43"	29	104 29'59.91"	48 17'36.17"
3	104 29'05.74"	48 17'42.4"	30	104 29'53.21"	48 17'36.13"
4	104 29'11.34"	48 17'42.43"	31	104 29'53.19"	48 17'37.36"
5	104 29'11.34"	48 17'41.91"	32	104 29'40.49"	48 17'37'31"
6	104 29'15.71"	48 17'41.93"	33	104 29'40.47"	48 17'39.37"
7	104 29'15.72"	48 17'40.96"	34	104 29'32.71"	48 17'39.93"
8	104 29'21.05"	48 17'40.98"	35	104 29'32.68"	48 17'42.52"
9	104 29'21.07"	48 17'39.3"	36	104 29'24.92"	48 17'42.49"
10	104 29'24.95"	48 17'39.32"	37	104 29'24.95"	48 17'43"
11	104 29'24.98"	48 17'36.92"	38	104 30'35"	48 17'43"
12	104 29'30.8"	48 17'36.95"	39	104 30'35"	48 16'50"
13	104 29'30.82"	48 17'36.94"	40	104 32'00"	48 15'50"
14	104 29'34.7"	48 17'36.96"	41	104 33'30"	48 15'50"
15	104 29'34.72"	48 17'33.01"	42	104 33'30"	48 14'47"
16	104 29'50.24"	48 17'33.08"	43	104 32'53"	48 14'47"
17	104 29'50.26"	48 17'32.08"	44	104 32'53"	48 14'30"
18	104 30'06.07"	48 17'32.08"	45	104 31'15"	48 14'30"
19	104 30'06.08"	48 17'32.15"	46	104 31'15"	48 15'00"
20	104 30'09.67"	48 17'32.15"	47	104 30'36"	48 15'00"
21	104 30'09.68"	48 17'31.92"	48	104 30'36"	48 16'10"
22	104 30'11.67"	48 17'31.92"	49	104 30'00"	48 16'10"
23	104 30'11.66"	48 17'30.75"	50	104 30'00"	48 17'00"
24	104 30'13.54"	48 17'30.72"	51	104 29'36"	48 17'00"
25	104 30'13.52"	48 17'32.86"	52	104 29'36"	48 17'16"
26	104 30'06.05"	48 17'32.83"	53	104 29'00'	48 17'16"
27	104 30'06.04"	48 17'34.38"			

Ар наймганы дунд хэсэг алтны шороон орд нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун хойш 249 км-т, Заамар сумаас 30 км-т, “Алтан дорнод Монгол” ХХК, “Шижир алт” ХХК-ний уурхайн тосгоноос 8 км зайд байрлана. Нийт замын хагас нь буюу Улаанбаатар хотоос 110 км хатуу хучилттай замтай ба бусад нь сайжруулсан шороон зам байдаг. Төвийн эрчим хүчний системд бүрэн холбогдсон бөгөөд 110 квт ба 10 квт өндөр хүчдэлийн шугамтай болно. Мөн үйлдвэрлэлийн усан хангамж бүрэн шийдэгдсэн, уул техникийн энгийн нөхцөлтэй зэрэг нь тухайн ордыг ашиглах боломжийг улам бүр нэмэгдүүлдэг юм.

Ордын район нь манай улсын томоохон алтны район бөгөөд одоогоор Монгол улсын алт олборлодог томоохон аж ахуйн нэгжүүд болох Монгол-Оросын хамтарсан “Монгол росцветмет” үйлдвэрийн харья “Шижир алт” ХХК, “Алтан Дорнод Монгол ”ХХК, мөн “Мон полимет” ХХК, зэрэг олон арван компаниуд ажиллаж Монгол улсын алтны ихэнх хувийг олборлож байна.

### **КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Төв аймгийн Заамар сумын нутагт “Ар наймганы дунд хэсэг” нэртэй газарт орших ашиглалтын талбайн MV-005028 дугаартай тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 10-р сарын 13-ны өдрийн тушаалаар 9011165058 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээтэй “Монгол Майнинг энд Эксплорэйшн” ХХК-д олгосон байдаг бөгөөд Улмаар АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020 оны 10 сарын 26-ны өдрийн тушаалаар 9011652113 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээтэй “Хаан булаг финанс” ХХК-д олгосон байдаг. Мөн Кадастрын хэлтсийн даргын 2021 оны 8 сарын 25-ны шийдвэрээр компанийн оноосон нэрийг “Хаан булаг интернэйшнл” ХХК болгон өөрчлөв.



“ Хаан булаг интернэйшнл” ХХК -ийн хамт олон

## **2. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Манай компани нь уулын ажлыг 2025 оны 03 сараас эхэлж, угаалгын ажлыг 4 сараас эхлэн 1 ш угаах төхөөрөмж, EX-1200, CAT-390, DOOSAN-700, LUIGONG LG-956L дугуйт ачигч, SINOTRUCK-371 автосамосвал, G-9190 автогрейдер, Komatsu D-155 маркын бульдозер, усалгааны машин, Land cruiser-105, 100, 80, 77, 76 зэрэг уурхайн хүнд ба хөнгөн тэрэг, машин тоног төхөөрөмж ажиллан, нийт 3,084.1 мян.м3 уулын цул хөдөлгөсөн байна.

2025 онд нийт хөрс хуулалт 3,003.23 мян.м3, элс олборлолт болон эфель,гааль 127.69 мян.м3 байна. 2025 онд уулын ажлаар нийт 8.4 га талбай шинээр эвдрэлд орж 15,297 м3 үржил шимт хөрсийг хуулж шимт хөрсний овоолгод байршууллаа.

Үүнд : Дотоод овоолго 3.603 мян.м3

## **3. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

### **3.1 Агаар**

Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх

**3.1.1 Агаарын бохирдлын мониторингийн цэгүүд байгуулж орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу жил бүр хяналт явуулах. Жил бүр олборлолтын ажил эхлэх үе буюу 4-5 саруудад эхний хэмжилтийг хийж байх. Мөн давтан шинжилгээг 9 сард хийлгэж байх**



Зураг.1 Агаарын бохирдлын мониторингийн цэгүүд байгуулж хэмжилт хийв. 5 сар

**3.1.2 Агаарын чанрын мониторингийн хэмжилтийг уурхайн ашиглалтын технологитой уяалдуулан хийж байх. Уурхай бүрэн хүчин чадлаар ажиллах үед, мөн хөрс хуулалт болон овоолго хийх үед агаарт агуулгдах тоосжилтын хэмжээг хэмжиж байх**

Тус ажлын хүрээнд бид уурхайн карьер, тээвэрлэлтийн зам, хотхоны орчим зэрэг газар агаарт буй ширхэглэгт тоосонцрыг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил, салхины хурд, агаарын температур, гэрлийн хүч зэргийг хэмжиж суурин боловсруулалтын хүрээнд тус хэмжиж авсан хэмжилтийг “Агаарын техникийн ерөнхий шаардлага ”MNS 4585:2016 стандарттай харьцуулсан.

Хүснэгт 1.

Агаарт буй тоосонцорыг хэмжсэн үзүүлэлтүүд

№	Байршил	Сар өдөр	Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> / мг/м <sup>3</sup>	Азотын хий /NO <sub>2</sub> / мг/м <sup>3</sup>	Нийт Тоосны агууламж TSP мг/м <sup>3</sup>	Дуу чимээ дБА	Чийг-шил
1.	Зам	05/04	0.020	0.056	0.231	30	max 40.4% min 18.4%
2	Хотхон	05/04	0.021	0.048	0.350	40	max 40.4% min 18.4%
	MNS 4585:2016 стандарт	-	<b>0.450</b>	<b>0.200</b>	<b>0.500</b>	60.0 дБА	40-60%



Зураг.2 Агаарын чанарыг хэмжсэн багаж

Монгол Улсын “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандарт нийт тоосны агууламж TSP мг/м<sup>3</sup>, Хүхэрлэг хий, Азотын давхар исэл зэрэг үзүүлэлт нь 24 цагийн дунджаар бидний хэмжилт хийсэн газруудад агаарын техникийн ерөнхий шаардлага стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.



*Зураг.3 Агаарын бохирдлын мониторингийн цэгүүд байгуулж хэмжилт хийв. 8 сар*

### **3.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөц**

**Ус шавхан зайлуулалтын улмаас газрын доорх усанд хомстол үүсэх**

**3.2.1 Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авч хамгаалалтын далан шуудууг засаж сайжруулж байх.**

Жил бүр гамшгийн эрсдэлийн үнэлгээ батлуулан ажиллаж болзошгүй үер усны аюулаас урьдчилан сэргийлж хамгаалалтын далан шуудууг засаж сайжрууллаа.



*Зураг.4 Үерийн далан сайжруулалт хийсэн байдал*

**3.2.2 Хүнд механизмын түлш, шатахуун зэрэг усыг бохирдуулагч бодис хаяж асгахгүй байх шаардлагатай. ШТМ-иар бохирлогдсон болон ахуйн бохирдол бий болсон хөрс хур борооны үеэр угаагдан гадаргын болон гүний усыг бохирдуулж болзошгүйг анхаарч ажиллах.**

Шатахуун түгээх хэсэг болон тос тосолгооны цэгийг хөрс хур борооны үеэр угаагдан гадаргын болон гүний усыг бохирдуулж болзошгүй байдлаас сэргийлж хатуу хучилттай болгосон.



*Зураг.5 Шатахуун түгээх хэсэг болон тос тосолгооны цэгийг хатуу хучилттай болгосон*

**3.2.3 Эргэлтийн усан сангийн далангаас ус алдаж болзошгүй тохиолдолд урьдчилсан арга хэмжээ авах, усан сангийн даланд хананы бэхлэгээ хийх, усан санг үерээс байнга хамгаалж байх**

Эргэлтийн усан санд хорт бодис, хог хаягдал, тос, шатахуун, бохир ус орохоос урьдчилан сэргийлж хашаажуулан, үерийн далан байгуулсан болно.



*Зураг.6 Үерийн далан хашаажуулалт хийсэн байдал*

**3.2.3 Алт угаах зорилгоор байгуулсан нуур цөөрмийн усны бохирдол нь газрын доорх усанд шууд нөлөөлөх тул газрын доорх усанд бохирдуулах бодис (хорт бодис, хог хаягдал, тос, шатахуун, бохир ус г.м) оруулахаас тогтмол урьдчилан сэргийлэх.**



*Зураг.7 Эргэлтийн уснаас тогтмол шинжилгээ авч, бохирдсон эсэхийг хянаж ажилласан.*

### **3.3 Хөрсөн бүрхэвч**

**3.3.1 Шимт хөрсний овоолгыг 2 жилээс хэтрүүлэхгүйгээр нөхөн сэргээх ажилд ашиглаж байхаар зохион байгуулах**

MNS 5916:2008 стандартын дагуу шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, гадны нөлөөлөлд автахаас урьдчилан сэргийлж хэлбэржүүлэлт хийсэн. Уурхайн шимт хөрстэй ажиллаж журмыг боловсруулж мөрдөн ажиллав.

*Хавсралт.7 Уурхайн шимт хөрстэй ажиллах журам*



Зураг.8 Шимт хөрсний овоолго

**3.3.2 Газрын гадарга хөрсийг элэгдлээс хамгаалахын тулд уурхайн тосгон орчимд мод,сөөг, олон наст ургамал тарьж ногоон байгууламж бий болгох, кемпийн талбайн явган хүн явах замд хайрга чулуу дэвсэх**

Тосгоны хашаанд нийт 5 зүйлийн 17 ширхэг мод бут тарьж ургуулсан бөгөөд явган хүн явах зам талбайг хатуу хучилттай болгож ажилласан.



Зураг.9 Кемпийн ногоон байгууламж, явган хүний зам

**3.3.3 Шатах тослох материал нь органик нэгдлүүдийн нийлмэл бөгөөд хөрсөнд нэвчсэн тохиолдолд түүний гүнд ихээхэн хэмжээний бохирдлыг бий болгон удаан хугацаагаар хадгалагддаг онцлогтой. Ингэж бохирдсон хөрсийг хуулан авч тусгаарлагч гадаргуу дээр овоолон 18-20%-ийн хлорамины уусмалаар бороожуулан ариутгаж эсхүл бууц хольж асган саармагжуулалт хийх**

Засварын хэсэгт, колонкийн хэсэгт асгаралт шингээгч материал / spill kit /, элс арчих материал зэргийг галын буланд байрлуулав. Мөн ашигласан тос тосолгооны материалыг 5 тн-ын багтаамжтай төмөр ёмкост цуглуулан байршуулж гэрээний дагуу дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлдэг.



*Зураг.10 Нефтийн бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд авах арга хэмжээ, Spill kit / Асгаралт шингээгч /*

#### **3.4 Ургамлан нөмрөг**

Уурхайн болон ажилчдын хотхоны үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч доройтох

**3.4.1. Ургамлан нөмрөгийг устах, талхлагдахаас сэргийлж хүн, техникийн хөдөлгөөнд хязгаарлалттай тавьж авто замуудаар зорчих хөдөлгөөнийг хэвшүүлж хяналт тавьж ашиглах, шороон асгацууд бий болгохгүй байх, талбайн ашиглалтын зохион байгуулалтыг сайжруулах**

Авто замуудаар зорчих хөдөлгөөнийг хэвшүүлж хяналт тавьж ажилласан ба салаа сам гарсныг хааж ажилласан



*Зураг.11 Нийт ажилчдад тогтоосон тээврийн замаас бусад газраар явуулахгүй байх талаар зааварчилгаа өгөв*

### **3.4.2 Тарилт хийхийн өмнө үрийн соёлох болон дасан зохицох чадвар, ус чийг, хуурайшилд хир зэрэг тэсвэртэй болохыг судалсан, биологийн үндсэн онцлогийг сайн мэдэх үрийг сонгох**

*/ Хавсралт.10 Ургамлын мониторинг судалгааны тайлан /*

#### **3.5 Амьтны аймаг**

### **3.5.1 Ажиллагсадад ан амьтан хамгаалах хууль дүрэм журмыг мөрдүүлэх, байгальд элдэв сөрөг үйлдэл гаргуулахгүй байхад анхаарч сурталчилгааны ажил тогтмол зохиож байх**

Хурдны хязгаарыг байнга барих, зам тээврийн үед амьтан алахгүй байх, амьтны нүүдлийн төлөв болон үржлийн хэв маягт саад учруулахгүй байх талаар сургалт явуулсан бөгөөд ажилчдад болон тээвэрлэлтэд оролцох ажилчдад хамгааллын статус бүхий ховор амьтдын ач холбогдол, ан агнуур, худалдааг хориглох тэмдэг байршуулсан.

### **3.5.2 Ан амьтны үхэж хорогдохоос сэргийлэхийн тулд уурхайн байгууламж руу ан амьтан орохоос хамгаалах арга хэмжээ авах, уурхайн ашиглагдсан талбайг нөхөн сэргээх**

Үүсэх карьер, нүх цүнхээлд ус тогтон нутгийн иргэд, мал, зэрлэг амьтад осолдохоос сэргийлж хашаа хамгаалалт хийсэн. Үүссэн хаягдал ус цуглуулах орчин болон бусад нүх хонхор газруудыг хашиж, амьтан орохоос хамгаалж далан шуудуу хийж хашаалсан. Мөн цахилгааны нийт 16 тулгуур дээр шувуу үргээгч байрлуусан.



*Зураг.12 Шувуу үргээгч*

#### **4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

##### **4.1 Биологийн нөхөн сэргээлт**

2025 онд техникийн биологийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй ба 2024 онд үйл ажиллагаа явуулагүй боловч 14.23 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн.

#### **5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.**

##### **5.1 “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” ний хүрээнд 5000 ширхэг мод тарих**

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд навчит модны суулгацаар “Заамар сумын төв”-д цэцэрлэгт хүрээлэнгийн хашаан дотор 300 метр газар ургамалан хашлага хэлбэрээр 5000 ширхэг мод тарив



*Зураг.13 Бэлдсэн шуудуугаа шимт хөрсөөр дүүргэж тарилт хийв. 10 сар*



*Зураг.14 Бэлдсэн шуудуугаа шимт хөрсөөр дүүргэж тарилт хийв. 10 сар*

## 5.2 Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд өртөн нөхөн сэргээгдээгүй үлдсэн талбайд

2025 онд 9 сард Дүйцүүлэн хамгаалах ажлаар Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн “Тосон” хэмээх газар 3.61 га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэлээ.



*Зураг.15 3.61 га техникийн нөхөн сэргээлт хийхээс өмнө*



*Зураг.16 3.61 га техникийн нөхөн сэргээлт хийсэний дараа*



*Зураг.17 3.61 га техникийн нөхөн сэргээлт харьцуулсан зураг*

## **6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад нүүлгэн шилжүүлэн, нөхөн олговор олгох арга хэмжээний ажил хийгдэхгүй болно.

## **7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### **7.1 Археологийн дурсгал**

Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний дагуу ШУТИС-ийн Бизнесийн удирдлага Хүмүүнлэгийн сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын археологи угсаатан зүйн судалгааны багаар нь 2019 оны 7-р сарын 19-нөөс 7-р сарын 21 хүртэл 2 хоногийн хугацаанд төслийн талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгүүлэхэд 11 дурсгалыг илэрсэн байна Хайгуулын ажлаар илэрсэн 11 дурсгалын 6 дурсгалыг 2019 оны 08-р сарын 10-аас 08-р сарын 25-ийн хүртэл 15 хоногийн хугацаанд ШУТИС-ийн Бизнесийн удирдлага Хүмүүнлэгийн сургуулийн Хүмүүнлэгийн ухааны

салбарын археологи-угсаатан зүйн судалгааны багаар авран хамгаалах малтлагын ажил гүйцэтгүүлсэн. Малтлага судалгааны явцад дурсгалууд нь Хүрэл зэвсгийн сүүл төмрийн түрүү үед холбогдох нь тогтоогдсон хэдий ч ихэнх чулуун байгууламжууд эрт үед тоногдсон байснаас гадна хоосон болон тахилгын шинжтэй байсан. 2025 онд түүх дурсгалын олдвор илрээгүй.

/Хавсралт.9 “Археологи угсаатан зүйн судалгаа” тайлан /

## 7.2 Палеонтологийн дурсгал

“Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 2014 оны 5 сарын 15 ны өдрийн шинэчлэн найруулгын 5.1.1; 6.1.5; 16.7.1; 17.1.3.4; 27.2; 28-р зүйл, 38,2,3; 60.1.10-д заасны дагуу газрын хэвлийн эзэмших ашиглахад палеонтологийн хайгуул тандан судалгааны ажлыг хийлгэх шаардлагатай байдаг.

2020 онд палеонтологийн судалгааг ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төвөөр гүйцэтгүүлсэн. Ордын хэмжээнд палеонтологийн дурсгал илрээгүй болно.

Хавсралт.12 Палеонтологийн тандан судалгааны тайлан дүгнэлт

## 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах

**8.1 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах**

“Хаан булаг интернэйшл” ХХК нь 2025.05 сард “Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх уул уурхайн аврах 09 дүгээр анги”-с Уурхайн,уулын үйлдвэрт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдлэг, дадлага олгох сургалтад авсан.

/Хавсралт.15 Сургалтад хамрагдсан сертификат/



Зураг.18 Сургалтад хамрагдсан ажилчид, сертификат

### 8.1.2 Аянга, цахилгаанаас үүдэлтэй аюул ослоос сэргийлэхийн тулд аянга зайлуулагч байрлуулах

Аянга, цахилгаанаас үүдэлтэй аюул ослоос сэргийлэхийн тулд аянга зайлуулагч, уурхайн шатахуун түгээгүүрийн газар байрлуулж ажилласан.



Зураг.19 Аянга зайлуулагч

### 8.1.3 Шороон шуурганаас үүдэх сөрөг нөлөөллүүдийг бууруулахын тулд байгууламжуудын битүүмжлэлийг сайн хийх, ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангах, шаардлагатай үед үйл ажиллагааг түр зогсоох

Ажлын байрны үзлэгээр хэсэг нэгжүүдэд тогтмол шалгалт хийн илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгаж техникийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. Засварын хэсэг нь тусгай зөөврийн бетонон шалтай, халаалт агааржуулалт гэрэлтүүлгийг бүрэн шийдсэн болно. Мөн тос тосол, үйлчилгээ хийх зориулалттай бетоноор бүрэн доторлосон нэг нүхэн яам шинээр байгуулсан.



Зураг.20 Засвар, үйлчилгээний төв, зөөврийн бетонон хавтан, бетоноор доторлосон нүхэн яам

#### 8.1.4 Үйлдвэрлэлд гарч болзошгүй аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж мөрдөх

Жил бүр ОБЕГ-ын харьяа Уул уурхайн аврах газраас 2025 оны Аваар устгах төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

*/ Хавсралт.11 Батлагдсан 2025 оны аваар устгах төлөвлөгөө /*

#### 8.2.1 Зохих стандартын шаардлага хангасан замын тэмдэг, тэмдэглэгээг шаардлагатай гэж үзсэн газруудад байрлуулана.

Стандартын шаардлага хангасан тэмдэг, тэмдэглэгээг ил уурхайн аюулгүйн дүрмийн дагуу, зам тээвэр, мөргөцөг гэх мэт шаардлагатай газар байрлуулан хэрэгжилтийг ханган ажиллаа.

- Уурхайн технологийн замд шаардлагатай замын тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан.

Үүнд:

Анхааруулах тэмдэг- 15ш

Хориглох тэмдэг -8ш

Дарааллын тэмдэг -8ш

Заах тэмдэг- 10ш



Зураг.21 Анхааруулах тэмдэгүүд



Зураг.22 Хориглох тэмдэгүүд



Зураг.23 Дарааллын тэмдэгүүд



Зураг.24 Заах тэмдэгүүд

### 8.2.2 Машин техник, хувцас хэрэглэлд гэрэл ойлгогч, дарцаг хэрэглэх

Нийт ажилчдыг НБХХ хангаж машин техникүүдэд гэрэл ойлгогчтой тууз наасан.



Зураг.25 Гэрэл ойлгогчтой тууз наасан техникүүд

### 8.3 Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж, олборлолтын үйл ажиллагаа доголдох, зогсох

#### 8.3.1 Болзошгүй аюулын үед ашиглах гарцаар хангах, аюулгүй ажиллагаа, аврах сургалт зохион байгуулах, цугларах цэг байгуулах

Жил бүр ОБЕГ-ын харьяа Уул уурхайн аврах газраас 2025 оны Аваар устгах төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Зураг.26 Цугларах цэг

### 8.3.2 Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдалд нэгж тус бүрийг удирдах ажилтан өдөр бүр тогтмол хяналт тавьж илэрсэн дутагдлыг биечлэн засах, холбогдох арга хэмжээг авч ажиллах

Шаардлагатай газруудад галын хорыг байрлуулж багаж хэрэгсэл байрлуулсан. Бэлэн байдалд галын машин байнга байдаг.



Зураг.27 Гал унтраах техник, багаж хэрэгсэл галын булан

### 8.3.3 Уурхайн галын аюул гарч болох газар, экскаватор, автосамосвал бүрт “Галын аюулаас урьдчилан сэргийлэх заавар”-т заасан гал унтраах хэрэгсэл, материал, багаж төхөөрөмж бэлэн хадгалсан байх

2025 онд уурхайд ашиглаж байгаа нийт 28 ширхэг хүнд болон, хөнгөн машинд гал унтраах хэрэгслийг байрлуулан бэлэн байдлыг ханган ажилласан.



Зураг.28 Автосамсвалдуудад галын хор байруулсан байдал



Зураг.29 Галын булан болон экскаворуудад галын хор байрлуулав.

## **9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### **9.1 Ахуйн хог хаягдал**

#### **9.1.1 Ахуйн хог хаягдлыг түр хадгалах цэг байгуулах. Мөн ус үл нэвтрүүлэгч материалаар хогийн цэгийн доод хэсэгт дэвсэж, гадуур нь хашаа татах тохижуулах**

Ангилан ялгалтын цэгийг тохижуулж, дахин боловсруулах, ашиглах боломжтой хог хаягдлыг цуглуулан ажиллав. Мөн шинээр хаягдал цаас хадгалах, цуглуулах байр хийлээ.



Зураг.30 Хатуу хог хаягдал түр хадгалах, ангилан ялгах байр

**9.1.2** Энгийн хог хаягдлаа ангилан ялгах хогийн сав нь “Хог хаягдлын тухай хууль”-ийн 15-р зүйлд заасны дагуу хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн, ангилан ялгах тэмдэг тэмдэглэгээтэй байна.

Стандартын шаардлага хангасан ангилан ялгалтын хогийн сав байршуулсан бөгөөд ангилан ялгасан дахин боловсруулах боломжтой хогоо, дахивар бүтээгдэхүүн авдаг хувь хүнд нийлүүлдэг.



Зураг.31 Ангилан ялгалтын хогын сав.

**9.1.3** Хог хаягдлын түр хадгалах цэг болон, хогийн савуудад ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байх шаардлагатай



Зураг.32 Жавлиний уусмал, хлорминоор ариутгал халдваргүйжүүлэлт хийв.

### 9.1.4 Нийт ажилчдад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх

2025 онд байгаль орчны зөвлөх үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллага болох “Газар Чандмань” ХХК хамтран 5 сард “Хуванцар савны, хэрэглээ байгальд үзүүлэх хор нөлөө” 8 сард “Хог хаягдал ангилан ялгалт” сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан болно. /Хавсралт.14 Сургалтад хамрагдсан ажилчдийн сургалтын протокол/



Зураг.33 Сургалтанд хамрагдсан ажилчид

## 9.2 Аюултай хог хаягдал

### 9.2.1 Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган хуримтлуулах

Хуучин тосны цэг гарган ажилласан тос тосолгооны материалаа хадгалсан. Мөн аккумулятор дахин ашигласанаар хаягдал гараагүй болно.



Зураг.34 Хуучин тосны цэг, байгуулж хашаажуулав.

## 9.2.2 Ашигласан тос тосолгооны материалыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

2025 онд “Ирмүүн ойл трейдинг” ххк-тай “Аюултай хог хаягдал цуглуулах тээвэрлэх, устгах зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид хаягдал шилжүүлэн өгөх гэрээ” байгуулан ажиллаа. / Хавсралт.14 Техникийн хаягдал тос, тосолгооны шингэний хаягдлыг хүлээлгэн өгөх гэрээ. Дагалдах бичиг /



Зураг.35 Дахин боловсруулах үйлдвэрт аюултай хог хаягдлаа нийлүүлэв.

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Хаан булаг интернэйшнл” ххк-ийн MV-005028 тусгай зөвшөөрлийн талбайд Алтны шороон ордын ашиглалтыг явуулж байгаа бөгөөд жил бүр орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Орчны хяналт шинжилгээний ажлыг 2025 оны 05-р сарын 09-наас 05-р сарын 11-ны өдрүүдэд экологич Э.Мөнгөнтуяа, Ө.Ундрах, ургамал судлаач Д.Отгонцэцэг нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн болно.

*Хавсралт.16 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тайлан 5 сар*

### 10.1 АГААРЫН ЧАНАРЫНХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Тус ажлын хүрээнд бид уурхайн карьер, тээвэрлэлтийн зам, хотхоны орчим зэрэг газар агаарт буй ширхэглэгт тоосонцорыг “Dust truck” багажаар, “Environmental meter” багажаар дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил, салхины хурд, агаарын температур, гэрлийн хүч зэргийг хэмжиж суурин боловсруулалтын хүрээнд тус хэмжиж авсан хэмжилтийг “Агаарын техникийн ерөнхий шаардлага ”MNS 4585:2016 стандарттай харьцуулсан



Зураг.36 Агаарын хяналт шинжилгээний багаж



Зураг.37 Агаарын чанарын хэмжмилт

Агаарын тоосжилтын үр дүн:

Монгол Улсын “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандарт нийт тоосны агууламж TSP мг/м<sup>3</sup>, Хүхэрлэг хий, Азотын давхар исэл зэрэг үзүүлэлт нь 24 цагийн дундажаар бидний хэмжилт хийсэн газруудад агаарын техникийн ерөнхий шаардлага стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 6. Агаарт буй тоосонцорыг хэмжсэн үзүүлэлтүүд 8 сар

№	Байршил	Сар өдөр	Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> / мг/м <sup>3</sup>	Азотын хий /NO <sub>2</sub> / мг/м <sup>3</sup>	Нийт Тоосны агууламж TSP мг/м <sup>3</sup>	Дуу чимээ дБА	Чийг-шил
1.	Зам	05/04	0.026	0.056	0.05	30	max 40.4% min 18.4%
2	Хотхон	05/04	0.050	0.048	0.05	30	max 40.4% min 18.4%
	<b>MNS 4585:2016 стандарт</b>	-	<b>0.450</b>	<b>0.200</b>	<b>0.500</b>	60.0 дБА	40-60%

## 10.2 ХӨРСНИЙ БОХИРДЛЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Хяналт шинжилгээний ажлын хүрээнд уурхайн засварын талбай, шатахуун түгээх газар, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хөрс, шимт хөрс зэргээс хөрсний дээж авлаа.



Зураг.38 Засвар, ШТС-ийн талбайгаас дээж авч буй байдал

### 10.2.1 Уурхайн шимт хөрсний шинжилгээ

Уурхайн шимт хөрсийг хуулахдаа 0.2м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолсон. Тус шимт хөрснөөс дээж авч хөрсний шимт чанарыг тодорхойлуулсан.



Зураг.39. Шимт хөрсний дээж авч буй байдал

## 10.3 УУРХАЙН УСНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

### 10.3.1 Уурхайн унд ахуйн усны шинжилгээ, хяналт

Уурхай нь улирлын чанартай ажиллах ба уурхайн хотхонд нийт 30-50 хүн ажиллаж амьдарна. Унд ахуйн усны хэрэгцээг өрөмдсөн гүний худгийн усаар хангана. Гүний худгийн

усанд шүүлтүүр тавьсан бөгөөд бид 5 дугаар сарын хяналт шинжилгээний ажлын хүрээнд тус уурхайн унд ахуйн усанд бактериологийн болон унд ахуйн усны ерөнхий шинжилгээг тус тус хийлгэж стандарт үзүүлэлттэй харьцуулсан болно.



Зураг.40 Ундны усны дээж авч буй байдал

### 10.3.2 Уурхайн технологийн усны шинжилгээ


Уурхайгаас баруун хойд байрлах цэвэр, бохир нуурыг элс баяжуулахад ашигладаг. Уурхайн элс баяжуулах хэсгийн хаягдлын сан, цэвэр нуурын уснаас тус тус дээж авч, цэврийн нуурын усны гадаргын усны инжилгээг Монгол-Ус ТӨҮГазарт хийлгэсэн бол



Зураг.41 Уурхайн цэвэрийн, бохирын нуурын уснаас дээж авч буй байдал

## 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 11.1 Уурхайн бүх ажлыг ил уурхайн аюулгүй байдлын дүрмийн дагуу явуулах, технологийн процессийг паспортжуулах



Зураг.42 Технологийн процесс, паспорт

### 11.2 Олборлолтын явцад археологи, палеонтологи, түүх, соёлын дурсгалт зүйлс илэрвэл сумын ЗДТГ, мэргэжлийн зохих байгууллагад яаралтай мэдэгдэж, авран хамгаалах арга хэмжээ авах

2022 онд архилоги, палентлогийн судалгаа хийлгэсэн болно.

### 11.3 Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл /газар хөдлөлт, үер, салхи шуурга/ болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1-2 удаа сургаж, дадлагажуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллах

“Хаан булаг интернэйшл” ХХК нь 2025.05 сард “Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх уул уурхайн аврах 09 дүгээр анги”-с Уурхайн,уулын үйлдвэрт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдлэг, дадлага олгох сургалтад авсан.

*/Хавсралт.11 Сургалтад хамрагдсан сертификат/*

### 11.4 Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч, ус, хөрс, агаарын бохирдол, хөрсний эвдрэл, элэгдэл, усны нөөцийн байдалд хяналт тавьж ажиллах

Орчны хяналт шинжилгээний ажлыг “Газар чандмань ххк” –аар 2025 оны 05-р сарын 04-наас 05-р сарын 7-ны өдрүүдэд экологич Э.Мөнгөнтуяа, Ө.Ундрах, ургамал судлаач Д.Отгонцэцэг нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн болно.

*Хавсралт.16 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тайлан 5 сар*


### 11.5 Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийлгэх /5 жил тутамд/

*Хавсралт.12 Газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгаа.*

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 12.1 Заамар сумын Хайлааст багийн иргэд

Уурхайн нөлөөллийн бүсэд орших малчдад нөхөн сэргээлтийн ажлын явц танилцуулсан мөн 2025 оны 10 сард Заамар сумын өдөрлөгт танилцууллага хийсэн.



Зураг.43 Сумын нээлттэй өдөрлөгт тухайн жилийн байгаль хамгаалах талаар хийсэн ажлыг танилцуулав.

## 12.2 Төв аймгийн Байгаль орчны газар

Мөн нөхөн сэргээлт хүлээж авах улсын комисст 09 сарын 19 ны өдөр талбай дээрээ биологийн нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн.

## 12.3 Төрийн захиргааны төв байгууллага

Цахим систем болох [www.eic.mn](http://www.eic.mn) 11 сарын 1-ний дотор бичвэр мэдээллийг орууллаа.

## 12.4 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

Хүснэгт 7. Байгаль орчныг хамгаалах зардлын нэгдэл

Д/д	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Үнийн дүн / мян.төг /	Үнийн дүн / мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2 700.0	2 700.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	43 720.0	43 720.00
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5 300.0	5 533.58
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1 400.0	1 400.0
7	Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	800.0	1 000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)	1 500.0	1 500.0
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1 000.0	1 000.0
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-	-
<b>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт</b>		<b>56 420.0</b>	<b>56 853.58</b>

### 13. ДҮГНЭЛТ

2024 онд биологийн нөхөн сэргээлтийг хадлан бэлчээрийн чиглэлээр хийсэн болно. Тарилтанд олон наст тухайн орон нутагт элбэг тархацтай ботуул, согоовор ерхөг гэсэн өвслөг ургамал мөн нэг наст тэжээлийн ургамал овъоёс, судан өвсийг 1:1:1:1 гэсэн харьцаатай үрийн холимог ашиглав. Тэжээлийн ургамал нь хөрсийг үндэсний системээр баяжуулан хөрсний шимэрхэг чанарыг дээшлүүлж, салхин нөмрөг үүсгэж өгдөг үр ашигтай. Нөхөн сэргээлт хийсэн талбайг хашиж хамгааллаж усалгаа арчилгаа хийснээр ургамлын ургалтын бүхий л үе шат хэвийн сайн явагдсан бөгөөд 9 сарын сүүлийн 10 хоногт үр боловсролт гүйцэж үрээ хаясан болно. Төлөвлөгөөт онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн ба бид тайланд төлөвлөгөөт аудит хийлгэсэн мөн “ Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд 5000 ширхэг мод тарилаа. Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл авч ажиллаа. Бид цаашдын үйл ажиллагаандаа Монгол улсад мөрдөгдөж байгаа байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын стандарт нормуудыг баримтлан ажиллана.



МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000232140

2017.06.15

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011652113

/ Хувийн хэргийн дугаар /

6195598

/ Регистрийн дугаар /

Хаан булаг интернэйшнл

Хязгаарлагдмал хариуцлагатай  
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2017.06.14

/ он, сар, өдөр /

4610

Гадаад худалдаа

8299

Бизнесийн зөвлөгөө өгөх

7320

Төсөл боловсруулах

7911

Аялал жуулчлал

08100

Ашигт малтмал ашиглах /2007.01.29-2037.01.29/

/ Код /

/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

3,010,000.00

/ хорөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 11-р хороо, зайсан, зайсангийн тойруу, 21/1 байр ММ проперти барилга  
1-3 давхар, Утас1: 77249999, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ

/ тэмдэг /

Т.ЗУЛЗАЯА

/ гарын үсэг /

Гэрчилгээ дахин олгосон 2021 он 07 сар 09 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Самбуу овогтой Идэр-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.06.15	Б.Батзориг
2	Дахин гэрчилгээ олгов.	2021.07.09	Т.Зулзаяа
3	Бямба овогтой Баярбаатар-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2023.09.21	Л.Пүрэвжаргал



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ  
**ЗӨВШӨӨРӨЛ**

Дугаар 5028А

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар  
зүйлийг үндэслэн

Төв аймаг /хот/-ийн  
Завсар сум /дүүрэг/-ын  
Ар найзганы дунд хэсэг нэртэй газарт орших  
1252 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд  
заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг  
зөвшөөрч улсын бүртгэлийн 9019007011 тоот гэрчилгээтэй  
„Атлан горнод монгол“ ХХК -д  
энэхүү тусгай зөвшөөрлийг 30 жилийн  
хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.



АМТХЭГ-ЫН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ

ДАРГА

Ц. ГАНХУЯГ

2007 оны 01 сарын 29 өдөр









Улаанбаатар хот

5028A

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ . . . . . 2901 ТООТ ЛИЦЕНЗИЙН  
ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ





**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН** (гэрчилгээгүй бол хүчингүй)

Лицензээр олгогдсон талбайн хэмжээ болон лицензийн эзэмшилд орсон оорчлолт

№	Лицензэд орох оорчлолтийн үндэслэл	Өргөдлийн бүртгэлийн дугаар	Хасагдах талбайн хэмжээ (га-аар)	Үлдсэн талбайн хэмжээ (га-аар)
1.	Анх олгосон	6658A	-	
2.	Лицензийг №354 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй "Газпромбанк" -д барьцаалуулсныг ГУУКА-ны даргын 2003 оны 43 тоот ишийдвэрээр бүртгэв.	165A		
3.	Лицензийн хоёр дахь жилийн төлбөрөө төлөв.			
4.	Лицензийн гурав дахь жилийн төлбөрөө төлөв.			
5.	Лицензийн 4 дахь жилийн төлбөрөө төлөв.			
6.	Лицензийг "Газпромбанк" ны 2005-12-22-ны өдрийн 08/5685 тоот хүсэлтийг үндэслэн барьцаалуулсныг бүртгэв.	498.1		
7.	Лицензийг 1027700167110 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй "Газпромбанк" -ийн даргын 2006 оны 219 тоот ишийдвэрээр бүртгэв.			
8.	Лицензийн 5 дахь жилийн төлбөрөө төлөв			
9.	Тусгай зөвшөөрлийн зургийн дахь жилийн төлбөрөө төлөв.			
10.	Тусгай зөвшөөрлийн 7 дахь жилийн төлбөрөө төлөв.			
11.	Тусгай зөвшөөрлийн 8 дахь жилийн төлбөрөө төлөв.			

5028 А  
**АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ . . . . . ТООТ ЛИЦЕНЗИЙН**  
**ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ**  
**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН** (гэрчилгээгүй бол хүчингүй)

*Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлын оорчлолтууд*

№	Солбицлууд оорчлогдох үндэслэл	Хүчин тоголдор солбицлууд
1.	Талбайн анхны солбицлууд	1. 104°29'00" 48°17'43" 28. 104°29'59.92" 48°17'34.36" 2. 104°29'05.74" 48°17'43" 29. 104°29'59.91" 48°17'36.17" 3. 104°29'05.74" 48°17'42.4" 30. 104°29'53.21" 48°17'36.13" 4. 104°29'11.34" 48°17'42.43" 31. 104°29'53.19" 48°17'37.36" 5. 104°29'11.34" 48°17'41.91" 32. 104°29'40.49" 48°17'37.31" 6. 104°29'15.71" 48°17'41.93" 33. 104°29'40.47" 48°17'39.37" 7. 104°29'15.72" 48°17'40.96" 34. 104°29'32.71" 48°17'39.93" 8. 104°29'21.05" 48°17'40.98" 35. 104°29'32.68" 48°17'42.52" 9. 104°29'21.07" 48°17'39.3" 36. 104°29'24.92" 48°17'42.49" 10. 104°29'24.95" 48°17'39.32" 37. 104°29'24.95" 48°17'43" 11. 104°29'24.98" 48°17'36.92" 38. 104°30'35" 48°17'43" 12. 104°29'30.8" 48°17'36.95" 39. 104°30'35" 48°16'50" 13. 104°29'30.82" 48°17'34.94" 40. 104°32'00" 48°15'50" 14. 104°29'34.7" 48°17'34.96" 41. 104°33'30" 48°15'50" 15. 104°29'34.72" 48°17'33.01" 42. 104°33'30" 48°14'47" 16. 104°29'50.24" 48°17'33.08" 43. 104°32'53" 48°14'47" 17. 104°29'50.26" 48°17'32.08" 44. 104°32'53" 48°14'30" 18. 104°30'06.07" 48°17'32.08" 45. 104°31'15" 48°14'30" 19. 104°30'06.08" 48°17'32.15" 46. 104°31'15" 48°15'00" 20. 104°30'09.67" 48°17'32.15" 47. 104°30'36" 48°15'00" 21. 104°30'09.68" 48°17'31.92" 48. 104°30'36" 48°16'10" 22. 104°30'11.67" 48°17'31.92" 49. 104°30'00" 48°16'10" 23. 104°30'11.66" 48°17'30.75" 50. 104°30'00" 48°17'00" 24. 104°30'13.54" 48°17'30.72" 51. 104°29'36" 48°17'00" 25. 104°30'13.52" 48°17'32.86" 52. 104°29'36" 48°17'16" 26. 104°30'06.05" 48°17'32.83" 53. 104°29'00" 48°17'16" 27. 104°30'06.04" 48°17'34.38"
2.	Лицензийг №354 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй "Газпром банк"-д барьцаалуулсныг ГУУКА-ны даргын 2003 оны 43 тоот шийдвэрээр бүртгэв.	2002-10-23  Д. Гэрэлгуйа Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 
3.	Лицензийн хоёр дахь жилийн төлбөрөө төлөв.	Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр. 
4.	Лицензийн гурав дахь жилийн төлбөрөө төлөв.	Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр №2004-10-19 
5.	Лицензийн 4 дахь жилийн төлбөрөө төлөв.	Лицензээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд хэвээр 





# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-005028

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Хөдөлгөөний код	Хөдөлгөөний тайлбар	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, гарын үсэг, огноо, тамга
000-C1	<ul style="list-style-type: none"><li>Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон.</li></ul>	1252.6 Га	0 Га	1 104° 30' 36" 48° 17' 44.83" 2 104° 30' 36" 48° 16' 51.82" 3 104° 32' 1.01" 48° 15' 51.82" 4 104° 33' 31" 48° 15' 51.82" 5 104° 33' 31" 48° 14' 48.81" 6 104° 32' 54" 48° 14' 48.81" 7 104° 32' 54" 48° 14' 31.81" 8 104° 31' 16" 48° 14' 31.81" 9 104° 31' 16" 48° 15' 1.82" 10 104° 30' 37" 48° 15' 1.82" 11 104° 30' 37" 48° 16' 11.82" 12 104° 30' 1.01" 48° 16' 11.82" 13 104° 30' 1.01" 48° 17' 1.82" 14 104° 29' 36.94" 48° 17' 1.8" 15 104° 29' 36.94" 48° 17' 17.8" 16 104° 29' 0.94" 48° 17' 17.8" 17 104° 29' 0.94" 48° 17' 44.82" 18 104° 29' 6.68" 48° 17' 44.82" 19 104° 29' 6.68" 48° 17' 44.21" 20 104° 29' 12.27" 48° 17' 44.24" 21 104° 29' 12.27" 48° 17' 43.72" 22 104° 29' 16.65" 48° 17' 43.74" 23 104° 29' 16.65" 48° 17' 42.77" 24 104° 29' 21.98" 48° 17' 42.78" 25 104° 29' 22.01" 48° 17' 41.11" 26 104° 29' 25.88" 48° 17' 41.14" 27 104° 29' 25.92" 48° 17' 38.73" 28 104° 29' 31.73" 48° 17' 38.76" 29 104° 29' 31.76" 48° 17' 36.75" 30 104° 29' 35.63" 48° 17' 36.77" 31 104° 29' 35.66" 48° 17' 34.82" 32 104° 29' 51.18" 48° 17' 34.89" 33 104° 29' 51.2" 48° 17' 33.88" 34 104° 30' 7.08" 48° 17' 33.9" 35 104° 30' 7.08" 48° 17' 33.97" 36 104° 30' 10.68" 48° 17' 33.97" 37 104° 30' 10.69" 48° 17' 33.75" 38 104° 30' 12.68" 48° 17' 33.75" 39 104° 30' 12.67" 48° 17' 32.58" 40 104° 30' 14.55" 48° 17' 32.54" 41 104° 30' 14.52" 48° 17' 34.68" 42 104° 30' 7.05" 48° 17' 34.65" 43 104° 30' 7.05" 48° 17' 36.2" 44 104° 30' 0.86" 48° 17' 36.16" 45 104° 30' 0.84" 48° 17' 37.98" 46 104° 29' 54.14" 48° 17' 37.94" 47 104° 29' 54.13" 48° 17' 39.17" 48 104° 29' 41.43" 48° 17' 39.12" 49 104° 29' 41.41" 48° 17' 41.18" 50 104° 29' 33.65" 48° 17' 41.74" 51 104° 29' 33.61" 48° 17' 44.33" 52 104° 29' 25.85" 48° 17' 44.29" 53 104° 29' 25.88" 48° 17' 44.82"







2010-04-01  
КАДАСТРЫН КЭЛТЭЭ  
УХАА 2/12  
Э.Заяабат



# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

**MV-005028**

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.






Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
000-CI	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон.</li></ul>	 2010-04-01
002-PL	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 354 тоот улсын бүртгэлийн дугаартай Газпромбанк гадаадын-д барьцаалах</li><li>Кадастрын хэлтсийн даргын 2003.01.23-ний 43 тоот шийдвэр</li></ul>	 2003-01-23
003-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2003.10.23 – 2004.10.23 хүртэл</li></ul>	 2003-05-12
004-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2004.10.23 – 2005.10.23 хүртэл</li></ul>	 2004-10-19
005-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 4 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2005.10.23 – 2006.10.23 хүртэл</li></ul>	 2005.10.14
006-PE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: 354 тоот улсын бүртгэлийн дугаартай Газпромбанк гадаадын-ийн барьцаанаас чөлөөлөх</li><li>Кадастрын хэлтсийн даргын 2005.12.22-ний 08/5685 тоот шийдвэр</li></ul>	 2005-12-22
007-PL	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 354 тоот улсын бүртгэлийн дугаартай Газпромбанк гадаадын-д барьцаалах</li><li>Кадастрын хэлтсийн даргын 2006.02.10-ний 219 тоот шийдвэр</li></ul>	 2006-02-10



# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-005028

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.




Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
008-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2006.10.23 – 2007.10.23 хүртэл</li></ul>	 200608-15
009-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2007.10.23 – 2008.10.23 хүртэл</li></ul>	 2007-08-10
010-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 7 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2008.10.23 – 2009.10.23 хүртэл</li></ul>	 2008.08.25
011-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 8 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2009.10.23 – 2010.10.23 хүртэл</li></ul>	 2009-10-20
012-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 9 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2010.10.23 – 2011.10.23 хүртэл</li></ul>	 2010-09-21
013-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 10 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2011.10.23 – 2012.10.23 хүртэл</li></ul>	 2011-10-03
014-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 11 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2012.10.23 – 2013.10.23 хүртэл</li></ul>	 2010-10-08



# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-005028

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
015-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 12 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2013.10.23 – 2014.10.23 хүртэл</li></ul>	 <p>2013-10-10</p>
016-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 13 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2014.10.23 – 2015.10.23 хүртэл</li></ul>	 <p>2014-09-16</p>
017-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 14 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2015.10.23 – 2016.10.23 хүртэл</li></ul>	 <p>2015-09-08</p>
